

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР
“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ
БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД
ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2024 оны 08 дугаар сарын 28-ны байдлаар/

2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын асуудлын хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшнийг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилго, зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын асуудлын хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 4 зорилтын 14 арга хэмжээ, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

АҮЭБЯ-ны хэрэгжүүлэх 4 зорилтын 14 арга хэмжээний биелэлт 2024 оны 08 дугаар сарын 28-ны байдлаар **58.0** %-тай дүгнэгдэв.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилгоор нь авч үзвэл:

- Зорилт 4.1. Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно зорилтын биелэлт **0.0** хувьтай.
- Зорилт 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно зорилтын биелэлт **56.3** хувьтай.
- Зорилт 4.4. Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө зорилтын биелэлт **50.0** хувьтай.
- Зорилт 4.6. Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн

зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно зорилтын биелэлт **100.0** хувьтай дүгнэгдлээ.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт /2024 оны 08 дугаар сарын 28-ны байдлаар/

Хүснэгт 1

Зорилго	Арга хэмжээний тоо	Үнэлгээ (хувь)							Хэрэгжилт (хувиар)
		100	90	70	50	30	13	0	
Зорилт 4.1. Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно	1	-	-	-	-	-	-	1	0.0%
Зорилт 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно	10	-	4	-	2	3	1	-	56.3%
Зорилт 4.4. Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнэ	1	-	-	-	1	-	-	-	50.0%
Зорилт 4.6. Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно	2	2	-	-	-	-	-	-	100.0%
Нийт дүн	14	2	4	-	3	3	1	1	58.0%

Хэрэгжилт хангалтгүй 5 арга хэмжээ байна. Үүнд:

- 4.1.17. Алт цэвэршүүлэх үйлдвэр болон бусад технологийн түүхий эдэд суурилсан гадаадын томоохон хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгийн экспоненциал өсөлтийг бий болгоход анхаарч ажиллана.
- 4.2.13. Уул уурхайн түүхий эдийг боловсруулан, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой байх зарчмаар хөгжүүлж, хөрөнгө оруулалтын дэвшилтэт хэлбэрүүдийг дэмжинэ.
- 4.2.16. Газрын тосны боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефьт-химийн үйлдвэр барьж байгуулна.
- 4.2.17. Гадаад, дотоод зах зээлд чиглэсэн гүн боловсруулалтын технологид суурилсан хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 4.2.18. Боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэлхийн брэндийн түвшинд хөгжүүлнэ.

Эдгээр 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрээгүй, боловсруулалтын шатанд байгаа буюу 0-30 хувиар үнэлэгдлээ.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

- “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 14 зорилт, арга хэмжээ, төслүүдийн хэрэгжилт 2024 оны байдлаар 58.0 хувиар үнэлэгдэв.

2. “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээгээр “бүрэн хэрэгжсэн” -холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан 6 /90%, 100%/, эрчимжүүлэх шаардлагатай 3 /50%/, хэрэгжилт хангалтгүй 5 /0-30%/ арга хэмжээ байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрэх түвшнийг жил бүрээр нарийвчлан гаргаж, хэрэгжилтийг хангах,
2. Тодорхой зорилт, арга хэмжээний хүрээнд дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүн, зарцуулсан хөрөнгийн талаар биелэлтийг бүрэн, тодорхой, оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнах,
3. Хэрэгжилт хангалтгүй байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлж, удирдлага зохион байгуулалтыг сайжруулахыг Үйлдвэр, технологийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт зөвлөмж болгох,
4. 4.1.17-д тусгагдсан “Алт цэвэршүүлэх үйлдвэр болон бусад технологийн түүхий эдэд суурилсан гадаадын томоохон хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгийн экспоненциал өсөлтийг бий болгоход анхаарч ажиллана.” зорилтыг Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангаж ажиллах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР
“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ
ТҮВШИНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/2024 оны 8 дугаар сарын 28-ны байдлаар/

2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшнийг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилго, зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын удирдлага болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

АҮЭБЯ-ны хэрэгжүүлэх 3 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 2024 оны байдлаар биелэлт **69.6** %-тай дүгнэв. Шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг авч үзвэл:

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ (%)
1.	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	100
2.	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	90
3.	Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь	19.0
	Биелэлт	69.6

2024 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилт хангалтгүй зорилтот түвшиндээ хүрээгүй, боловсруулалтын шатанд байгаа 1 шалгуур үзүүлэлт байна. Үүнд:

- Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээгээр 2024 оны байдлаар “бүрэн хэрэгжсэн” холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан 2 /90%, 100%/, хэрэгжилт хангалтгүй 1 /19%/, шалгуур үзүүлэлт байна.
2. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-д “Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро-5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь” шалгуур үзүүлэлтийн 2024 оны зорилтот түвшнийг 50 хувь гэж заасан. Тус шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, үүссэн нөхцөл байдлыг тодруулбал дотоодын үйлдвэр ашиглалтад орох явц төлөвлөгөөт хугацаанаас удаашралтай байгаа, Евро-5 стандартын хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор үнийн хөнгөлөлт болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч төдийлөн үр дүнд хүрээгүй, шатахууны хориг арга хэмжээ, оросын дотоодын төмөр замын ачаалал, түүнд олгох зөвшөөрөл, газрын тосны бүтээгдэхүүний экспортыг түр хориглох тухай тогтоолуудаас шалтгаалсан байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрэх түвшнийг жил бүрээр нарийвчлан гаргаж, хэрэгжилтийг хангах,
2. Тодорхой зорилт, арга хэмжээний хүрээнд дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүнгийн талаар биелэлтийг бүрэн, тодорхой, оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**“АЛСЫН ХАРАА – 2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ**

2024.08.28

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2024 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
Дөрөв. ЭДИЙН ЗАСАГ							
1	4.1. Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно.	4.1.17. Алт цэвэршүүлэх үйлдвэр болон бусад технологийн түүхий эдэд суурилсан гадаадын томоохон хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгийн экспоненциал өсөлтийг бий болгоход анхаарч ажиллана.	2020 - 2050			<p>“Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэр байгуулах” төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэс алт ресурс” ХХК 2020-2021 онд олон улсын 20 гаруй компанитай холбоо тогтоож төсөл дээр санал авсан ба “түлхүүр гардуулах” нөхцөлөөр 4 компани (Сымбат инженеринг, Шинхай групп, “Кронимет Майнинг, Зижин Майнинг) санал ирүүлсэн. “Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаарх санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий” ажлын хэсгийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021.10.01-ний өдрийн А/100 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн дүгнэлтийг 2021.12.09-ний өдрийн 03/678 дугаар албан бичгээр УУХҮЯ-нд ирүүлсэн. Дүгнэлтээр:</p> <ol style="list-style-type: none"> ТЭЗҮ нь Монгол Улсад мөрдөгдөж буй эрх зүйн үндэслэлийг тооцоогүй, эдийн засгийн тооцоолол бүхэлдээ буруу хийгдэж алдаатай болсон, төслийг хэрэгжүүлэх эрсдэлтэй тул дахин шинээр хийх; “Сымбат инженеринг” ХХК-тай цаашид ажиллахгүй тохиолдолд төсөлд оролцохоор ирүүлсэн хамгийн сайнаар үнэлэгдэх санал болох БНХАУ-ын “Шинхай групп”-ийн саналтай дүйцэх саналыг хэрэгжүүлэх; Цэвэршүүлэх алт мөнгөний жилийн хүчин чадлыг Монголбанкинд 1990 оноос хойш аж ахуй нэгж байгууллага, иргэдийн тушаасан алт мөнгөний хэмжээ, нөөц, уул уурхайн компаниудын хэтийн төлөв, ирээдүйд хэрэгжих томоохон төсөл хөтөлбөр, хэмжээ, нөөцийг харгалзан үзэж жилд 30 	0

					<p>хүртэл тн алт, 50 хүртэл тн мөнгө цэвэршүүлэх, хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх боломжтойгоор төлөвлөх;</p> <p>4.Эдгээр хувилбаруудаас хамгийн боломжит хувилбар “Түлхүүр гардуулах” төсөл хэрэгжүүлэгчээр өөрөөр нь санхүүжих, 8-10 жилийн урт хугацааны гаднын банкны хөнгөлөлттэй зээлд хамрагдах хувилбарыг судлах гэсэн дүгнэлт гарсан.</p> <p>БНКаЗУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яаманд 2023.02.17-ны өдрийн 02/475 албан бичгээр БНКаЗУ-ын “Сымбат инженеринг” ХХК-тай цаашид баримтлах байр сууриа УУХҮЯ-ны зүгээс илэрхийлсэн бөгөөд 2024 оны 08 дугаар сарын байдлаар төслийн хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүй хэвээр байна.</p>	
2	4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.	4.2.1. Нэмүү өртөг шингээсэн уул уурхай, стратегийн мега төслүүд, боловсруулах аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч, тээвэр, логистик, төрөлжсөн аялал жуулчлал, түүнийг дагасан үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэл, мэдлэгжсэн бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.	2020 - 2050		<p>Уул уурхайн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 28 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 70 хувь, экспортын орлогын 94 хувийг тус тус бүрдүүлэгч эдийн засгийн гол тулгуур салбар болсон.</p> <p>Төсвийн тухай хуулиар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 65%-ийг ирээдүй өв санд хуваарилж байна. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлж байгаа орлогын бүтцийг салган авч үзвэл газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30%, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 10%, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 100%, ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 50% байна.</p> <p>Өөрөөр хэлбэл, Монгол Улсын 21 аймаг, 365 сум бүр дээр дурдсан Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаар дамжуулан уул уурхайн салбараас тодорхой хэмжээний төсвөө бүрдүүлж байна.</p> <p>Боловсруулах аж үйлдвэрийг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх хүрээнд Хүнд үйлдвэрийн салбараас Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” байгуулах төсөл, “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах” болон “Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх” төслүүд, Оюутолгойн ордыг түшиглэн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр” байгуулах төсөл, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг түшиглэн “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төсөл, Дорноговь аймагт “Алтанширээт үйлдвэрлэл технологийн парк” байгуулах зэрэг</p>	50

						хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан нэмүү өртөг шингэсэн, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, шинээр ажлын байр бий болгох мега төслүүдийг хэрэгжүүлэхээр "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.2.14, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.2.11, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.7, Шинэ сэргэлтийн бодлого 2022-2025 зэрэг МУ-ын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусган ажиллаж байна.	
3		4.2.11. Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ.	2020 2050	-		<p>Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын дунд байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлгүй техник, технологи ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа шилдэг аж ахуйн нэгж байгууллагыг жил бүрийн жилийн эцэст шалгаруулан урамшуулах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн ордод өнөөгийн байдлаар Төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" ХК, орон нутгийн өмчит "Тавантолгой" ХК, хувийн хэвшлийн "Энержи ресурс" ХХК-иуд ажиллаж байна.</p> <p>"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийг түшиглэн нүүрс баяжуулах үйлдвэр, цахилгаан станц, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслүүд хэрэгжиж байна. Дээр дурдсан төслүүд хэрэгжсэнээр олборлолт, боловсруулалт, борлуулалтын түвшин нэмэгдэж, цахилгаан эрчим хүчний хэрэгцээг дотоодоос хангах, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай тээврийн дэд бүтэц бүрдэх юм.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд хэрэгжүүлж буй томоохон төслийн нэг Зүүнбаян-Ханги чиглэлийн 226 км төмөр замыг барьж байгуулан ашиглалтад оруулсан. Ханги-Мандалын боомтыг төмөр замаар холбож, шинэ гарц нээснээр манай улсын импорт, экспортын бараа бүтээгдэхүүний нэвтрэх хүчин чадал нийт 20 сая тонноор, төмөр замаар тээвэрлэгдэж байгаа нийт</p>	90

					тээврийн хэмжээ 65 хувиар тус тус нэмэгдэх боломжтой болж байна.	
4		4.2.12. Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөнө.	2020 2050	-	<p>Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа гадаад, дотоодын стандартыг шаардлагад нийцүүлэн дараах стандартуудыг батлуулсан.</p> <p>1. “Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал MNS 6457:2022” стандартын төслийг ажлын хэсгийн гишүүдтэй хамтран шинэчлэн боловсруулж, Гаалийн ерөнхий газрын Гаалийн төв лаборатори, Татварын ерөнхий газрын саналыг тусган, “Нүүрсний чанарын ангилал MNS 6457:2023” нэртэйгээр стандартын төслийг Уул уурхай, ашигт малтмалын стандартчиллын техникийн хорооны хэлэлцүүлэн Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн С/19 дүгээр тушаалаар батлуулсан.</p> <p>2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/97 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс “Төмрийн хүдэр, баяжмал болон төмрийн бүтээгдэхүүн. Техникийн шаардлага MNS 7017:2023”, “Хайлуур жонш. Марк ба техникийн шаардлага MNS 0145:2023” стандартуудыг хороогоор хэлэлцүүлж, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн С/39, 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн С/40 дугаар тушаалаар тус тус батлуулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 79 дугаар тогтоолоор батлагдсан хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт хяналт шалгалт 5, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 8 хийж гүйцэтгэн хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжид улсын ахлах байцаагчийн хугацаатай албан шаардлага 5, салбарын ерөнхий байцаагчийн албан даалгавар 1, улсын ахлах байцаагчийн акт 13 гарган хэрэгжилтийг хангуулсан бөгөөд нийт зөрчил бүхий 12 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар 136 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцон бүрэн барагдуулсан байна. Мөн Улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 06-00/004 дугаартай удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Хан богд сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Оюутолгой ХХК-ийн уурхайн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж танилцуулга, улсын байцаагчийн 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 006-00/012-006 дугаартай албан шаардлага боловсруулж хүргүүлэв.</p>	90

5		<p>4.2.13. Уул уурхайн түүхий эдийг боловсруулан, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой байх зарчмаар хөгжүүлж, хөрөнгө оруулалтын дэвшилтэт хэлбэрүүдийг дэмжинэ.</p>	2020 2050	-	<p>Нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлын хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:</p> <p>1. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах төслийн хүрээнд хийгдэж буй ажлууд:</p> <p>ҮТП-ийн газар: Засгийн газрын “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 2022 оны 171 дүгээр тогтоолын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк барих зориулалтаар 1217.4 га газар ашиглах 2022/185 дугаартай гурвалсан гэрээг УУХҮЯ, ГЗБГЗЗГ, Орхон аймгийн засаг дарга хооронд 2022.10.25-ны өдөр байгуулж, тус гэрээний дагуу ҮТП-ийн 2022.11.14-ний өдрийн №000000019 дугаартай Газрын гэрчилгээг УУХҮЯ-ны нэр дээр авсан. Үйлдвэрлэл технологийн паркийн газрын 1:500 масштабтай байрзүйн дэвсгэр зургийг боловсруулсан.</p> <p>- ҮТП-ийн газрыг тойруулан хашаа барих ажлын тендерт шалгарсан “Орчлон тулга” ХХК-тай 2022.12.05-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг “ЭҮ” ТӨҮГ байгуулсан бөгөөд нийт 16.3 км урттай хашаа баригдах ба одоогоор 15 км баригдсан. Мөн газрын хил хязгаар, дэд бүтцийн зураг төслийн давхцал, эргэлтийн цэгийг тэмдэгжүүлж, солбицол тодорхойлох, шалгах ажил хийгдсэн. /ажлын явц 91%/</p> <p>- Авто зам барьж байгуулах ажлын тендерийг 2022.06.30-наас эхлэн 4-н удаа зарлаж, Багц-2 буюу автозамын гэрэлтүүлэг барьж байгуулах тендерт "Оркон тех" ХХК шалгарч, Багц-1 буюу автозам барьж байгуулах ажлын тендерт "Шилдэг зам" ХХК шалгарч, 2024.11.01-ний өдөр хүртэлх хугацаагаар тус тус гэрээ байгуулан ажиллаж байна. /Ажлын явц 39%/</p> <p>- Төмөр зам барьж байгуулах ажлын тендерийг 2022.09.05-наас эхлэн 2 удаа зарлаж "Туулын гүүр далай" ХХК болон “ЭҮ” ТӨҮГ хооронд 2023.01.11-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан (69% буюу 9,791.8 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид шилжүүлсэн). Газар шорооны ажил 2023.04.09-ний өдрөөс эхэлж төмөр замын дэр бетоныг ажлын талбайд буулгасан ба ул хөрсний төлөвлөгдөөгүй нэмэлт ажил болон цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан гэрээний хугацаанд ажил гүйцэтгэх боломжгүй болж, гэрээг сунган үйл ажиллагаа явагдаж байна. Тус ажлын хүрээнд Төмөр замын захиалагчийн</p>	30
---	--	--	--------------	---	--	----

					<p>хяналтын зөвлөх үйлчилгээний тендэрт "Рэйлвэй консалтинг Сервис" ХХК шалгарч, 2023.11.09-ний өдөр гэрээ байгуулан ажиллаж байна. /Ажлын явц 72%/</p> <p>- Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын тендерийг 2022 оны 05 дугаар сараас эхлэн зарласан боловч СЯ, ШӨХТГ-т гомдол гарах, тендер хүчингүй болох зэрэг шалтгаануудаар өнөөдрийг хүртэл гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж чадаагүй байна. 2023.06.23-ны өдөр шүүх хурал болж, тендэрт оролцогчийн гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэж, тендерийг дахин зарлах эрх зүйн байдал үүссэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг АУХААХ-с 2023.08.03-ны өдөр дахин зарласан боловч ШӨХТГ-т гомдол гарсан тул гомдлыг хянан шалгах үйл ажиллагаа үргэлжилж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр гарч "Б-софт" ХХК-тай 2023.12.13-ны өдөр гэрээ байгуулсан ба гэрээнд заасны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Бохир усны Ф400мм голчтой ширмэн хоолой 790м, HDPE 110 мм голчтой 1570м, 250мм голчтой 3126м, нийт 5486 м шугамыг угсарсан. 2. Бохир усны Өргөлтийн насос станц №1,2,3,5 -ын суурийн газар шорооны ажил хийж суурийн бэлтгэл бетон суурь, ханын цутгалт, худгийн цутгалт хийсэн. 3. Авто зам, төмөр замын 4 хэсэг газарт бохир усны 104м урттай шугамыг сүвлэж байрлуулсан. 4. Цэвэр усны 300 мм 4350м урт цайрдсан ган хоолойг мөн угсарч дууссан байна. /Ажлын явц 35%/ <p>- ҮТП-ийн цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг 2022 оны 05 дугаар сард ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. ТЭЗҮ, Диспетчерийн үндэсний төв горимын тооцоо зэргийг үндэслэн, ЭХЯ-наас ҮТП-ийн цахилгаан хангамжийн техникийн нөхцлийн дагуу 2022.10.28-ны өдөр цахилгаан хангамжийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан ирүүлсэн. Уг ажлыг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Зураг төслийн хүрээлэн болон "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ гүйцэтгэж байгаа бөгөөд 220 кВт-ын дэд станц, ЦДАШ-ын зураг төслийн ажлын явц 89%, 110 кВт-ын дэд станц, ЦДАШ-ын зураг төслийн ажлын явц 100%, Нийт ажлын гүйцэтгэл 95%.</p>
--	--	--	--	--	--

					<p>2. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд:</p> <p>"Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ"-ийг Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2022.06.22-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж ТЭЗҮ-ийг хүлээн авахаар шийдвэрлэсэн. Үйлдвэрийн ТЭЗҮ-ээр зэсийн үнэ 8340 \$/тн-ны түвшинд 762 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан.</p> <p>- ЗБХБҮ-ээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinxin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна. Үйлдвэрлэлийн туршилтын хамтарсан гэрээний дагуу "ЭҮ" ТӨҮГ нь туршилтад ашиглах 500 тн шигшсэн нүүрс бэлтгэх ажлыг 2023.07.20-ны өдрөөс 2023.08.26-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэж, БНХАУ-руу тээвэрлэх ажлыг зохион байгуулан 2023.09.29-ний өдөр туршилтын үйлдвэрийн талбайд хүргүүлсэн. Үйлдвэрлэлийн туршилтын ажлыг 2023.09.26-ны өдөр эхэлсэн ба туршилтын урьдчилсан үр дүнгээр үйлдвэрийн үндсэн үзүүлэлтүүд тодорхойлогдсон тул батлагдсан ТЭЗҮ-ийг шинэчлэн, тодотгол хийж холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх хүсэлтийг УУХҮЯ-нд ирүүлээд байна.</p> <p>- ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-д өгсөн зөвлөмжийн дагуу "Аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж үндэсний болгон боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээ"-ний тендерийг 2022.11.02-нд нээж, "Эс Ай Си Эй" ХХК шалгарч, 2022.11.28-нд гэрээ байгуулан ажиллаж байна. Гүйцэтгэгчээс ирүүлсэн эхний болон дундын тайланг "ЭҮ" ТӨҮГ-аас байгуулагдсан ажлын хэсэг хүлээж авсан. Олон улсын туршлагыг судалсан судалгааны үр дүнд үндэслэн үндэсний болгон батлуулах стандартуудыг хэлэлцэж, 4-н стандарт сонгосон. Одоогоор стандартуудын эх хувийг авах, орчуулах ажил эхэлсэн бөгөөд зөвлөх багаар хянагдаж байна. Энэ нь хугацаа их шаарддаг тул гэрээг 2025.07.28-ны өдөр хүртэл</p>
--	--	--	--	--	---

					<p>сунгах ажил хийгдэж байна. 60%-ийн /207.6 сая төгрөг/ санхүүжилт хийгдсэн. Ажлын явц 80%.</p> <p>- Судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна. Мөн "Фосфорын ордыг ашиглах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил"-ыг ШУТИС-ын УУХ-ГУУС-тай гэрээ байгуулан ажиллаж, тайланг хүлээн авсан /ажлын санхүүжилт 148.8 сая төгрөг/.</p> <p>- Фосфорын ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах ажил"-ыг төлөвлөсөн боловч фосфорын ордыг ашиглалтын лиценз хувийн компанийн эзэмшилд байдаг шалтгаанаар гүйцэтгэх боломжгүй болсон.</p> <p>- ЗБХБҮ-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг "Хатан далай" ХХК гүйцэтгэсэн. БОАЖЯ-ны мэргэжлийн комиссын 2023.08.30-ны хуралдаанаар тайланг хүлээн авахаар шийдвэрлэсэн /ажлын санхүүжилт 118.8 сая төгрөг/. Ажлын явц 100%.</p> <p>- ЗБХБҮ-ийн техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж батлуулан тендерийг зарласан бөгөөд 6 удаагийн тендер хүчингүй болж 2024.04.11-ны өдөр дахин зарласан.</p> <p>- Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан АҮЭБ-ийн сайдын 2024.07.30-ны өдрийн 01/40 албан бичгээр Монгол Улсын Шадар сайд, Үндэсний хороо, ЗГХЭГ болон 16 яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.</p> <p>3. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах SX-EW технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэр байгуулах төсөл:</p> <p>"SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах" зөвлөх үйлчилгээний гэрээг "ЭҮ" ТӨҮГ болон "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-хооронд 2021.09.17-ны өдөр байгуулж, тус гэрээний дагуу катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулж УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хурлаар 2022.06.24-ний өдөр хэлэлцүүлсэн. Мөн "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн</p>
--	--	--	--	--	--

					<p>зөвлөлийн 2022.10.13-ны өдрийн хурлаас "Гүйцэтгэгч компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Техникийн зөвлөлөөр хэлэлцэх"-ээр шийдвэрлэсний дагуу Техникийн зөвлөлийн 2022.11.02, 04-ний өдрүүдийн хурлаар хэлэлцсэн.</p> <p>Гүйцэтгэгч тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр 2023.04.04-ний өдөр хэлэлцүүлж, АМГТГ-ын даргын "Техник эдийн засгийн үндэслэл бүртгэх тухай" 2023.04.21-ний өдрийн Т/39 дугаар тушаалаар ТЭЗҮ-ийг хүлээн авсан.</p> <p>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас байгуулагдсан ажлын хэсгийн 2023 оны Х/05; Х/30; ХИ/22-ны өдрүүдийн хурлаас гүйцэтгэгч компанийн боловсруулсан үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийн ажлын гүйцэтгэлийг хангалтгүй гэж дүгнэсэн. "ЭҮ" ТӨҮГ-ийн дээд шатны удирдагууд тус гүйцэтгэгч компанийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж гэрээний үүргээ биелүүлээгүйг анхааруулсан ба гүйцэтгэгч компанийн захирал хүлээн зөвшөөрч, тайлбарыг албан бичгээр ирүүлэхээ илэрхийлсэн байна.</p> <p>- Исэлдсэн хүдрийг HL-SX/EW технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэрийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажлын тендерт "Төгрөг баян хангай" ХХК шалгарч Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай 2023.10.26-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна.</p> <p>- Исэлдсэн хүдрийг HL-SX/EW технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэрийн Техник, технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлын гэрээг ШУТИС-ийн МТС-тай 2024.02.14-ний өдөр байгуулсан ба гэрээний дагуу гүйцэтгэн, хуучнаар УУХҮЯ-ны холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр албан хүсэлт ирүүлж, УУХҮ-ийн ТНБД-ын 2024.06.14-ний өдрийн А/66 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p> <p>4. Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК-ийн хэрэгжүүлж байгаа "Монгол ган цогцолбор I" төсөл: <u>2022 онд хийгдсэн ажил</u> "Эдийн Засаг Хөгжлийн Яам" /хуучнаар/ нь "Кью Эс Си" ХХК-тай 2014 онд байгуулсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг ЗГ-ын 2022.04.13-ны өдрийн 148 дугаар тогтоолоор цуцалсан. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн захирлын түр орлон гүйцэтгэгч, болон ТУЗ-ийг ТӨБЗГ-ын даргын тушаалаар томилж,</p>
--	--	--	--	--	--

					<p>үйлдвэрийг ТӨХК-ийн статустай болгож, үйл ажиллагааг жигдрүүлэх, төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, хэрхэн үргэлжлүүлэх хувилбар боловсруулах зэрэг ажил хийгдсэн. Гэрээ цуцалсантай холбоотойгоор төслийн ажил түр зогсолтод орсон ба гэрээ цуцлах хүртэл хугацаанд доорхи ажлууд хийгдсэн. Үүнд:</p> <p>“Кью Эс Си” ХХК нь жилд 350 мян.тн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай “Монгол ган цогцолбор 1” төслийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын “MCC-CERI”, Монгол Улсын “Кью Эм Си” ХХК-иудаар гүйцэтгүүлж ЭБМЗ-ийн 2021.09.30-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан.</p> <p>“Кью Эс Си” ХХК нь ТЭЗҮ-д туссан төсөл хэрэгжүүлэх хуваарийг нарийвслан гаргаж 2022.02.16-ны өдрийн 9/22 дугаар албан бичгээр УУХҮЯ-нд ирүүлсэн.</p> <p>Уг төлөвлөгөөний дагуу 2022 оны 4 дүгээр сар хүртэл хугацаанд дараах ажлууд хийгдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн зөвлөх компаниар Канад Улсын Hatch компанийг шалгаруулж, гэрээ байгуулсан. ✓ Төмөртэйн ордын төмрийн хүдрийн дээжийг усан онгоцоор тээвэрлэн Канад улсын Монреал хотод 2022 оны 03 сард хүргэн “Эс Жи Эс” лабораториор технологийн туршилт хийлгэж эхэлсэн. ✓ Шинэ нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн концепцийн ажлын даалгаврыг төслийн зөвлөх компани болох Хатч компанитай хамтран боловсруулж, гадны компаниудаас үнийн санал авсан. ✓ Шинэ цогцолбор үйлдвэрийн инженерингийн дизайны ажлын даалгаврыг Хатч компаниар хийлгэж хүлээн авсан ба манай талаас танилцаад санал, комментоо өгсөн. ✓ Мөн төслийн ТЭЗҮ-ийг боловсруулсан БНХАУ-ын MCC-CERI компанид инженерингийн дизайны ажлын даалгаврыг бэлэн болохоор явуулахаар ярьж тохиролцсон. ✓ Төслийн БОННУ-г хийлгэхээр бэлэн болсон ажлын даалгаврын дагуу дотоодын 6 компаниас үнийн санал авч сонгон шалгаруулалтыг хийх ажил хийгдсэн. ✓ Цогцолбор үйлдвэрийн боловсон хүчинг бэлтгэх хөтөлбөрийн төсөл, төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан. 	
--	--	--	--	--	--	--

					<p>✓ Төслийн газар шорооны ажлын урьдчилсан тооцооллыг хийсэн.</p> <p><u>2023 онд хийгдсэн ажил</u> “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК нь 2023 оны бизнес төлөвлөгөөг “Эрдэнэс Монгол” ХХК-иар, худалдан авалтын төлөвлөгөөг Сангийн ямаар 2023 оны 04 дүгээр сард тус тус батлуулсан. Төслийн ажлын хүрээнд дараах ажлуудыг 2023 онд хийж гүйцэтгэсэн. Үүнд: -Төсөлд шаардлагатай нэмэлт 77.7 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай Засгийн газрын 2023.04.19-ний өдрийн 145 дугаар тогтоол гарсан. -Төслийн гадна цахилгаан хангамжийн ТЭЗҮ, зураг төслийн ажлын санхүүжилтийг 2024 оны Улсын төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулсан. -Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн цахилгаан хангамжийн горимын тооцоог Диспетчерийн үндэсний төвөөр хийлгэж хүлээн авсан. - Төслийн газар шорооны тэгшилгээний ажлыг 9-10 сард гүйцэтгэж нийт 417,477 м3 хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэсэн. - “Эрдэнэс Монгол” ХХК-иас “Монгол ган цогцолбор I” төслийн концепци, хүчин чадлыг өөрчлөн 1 сая тн бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” байгуулах төслийг хэрэгжүүлэх чиглэл өгсөн тул төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) хийлгэх ажлыг гүйцэтгэгч компанид мэдэгдэл хүргүүлж ажлыг зогсоосон.</p> <p><u>Төмөрлөгийн үйлдвэрийн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн ажил:</u></p> <p>-“Мини шууд ангижруулсан төмрийн үйлдвэр”-ийн төсөл хэрэгжүүлэх хүрээнд “Металлурги, дэвшилтэт технологийн судалгааны төв” болон “Эрдэнэс ҮТП” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу төслийн ТЭЗҮ-ийг боловсруулахад зориулж ШУТИС-ийн Механик, тээврийн сургуулийн “Металлурги, дэвшилтэт технологийн судалгааны төв”-өөр шууд ангижруулсан төмрийн технологийн туршилтыг хийлгэж эцсийн тайлан ирүүлсэн. Тус 100 мян.тн/жил хүчин чадалтай шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн төслийн ТЭЗҮ-ийг “Эрдэнэс</p>
--	--	--	--	--	---

					<p>ҮТП” ХХК боловсруулж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023.11.28-ны өдрийн 01/1011 дугаар албан бичгээр төслийн шинжээч томилж, ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг УУХҮ-ийн яаманд ирүүлсний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А-353 дугаар тушаалаар шинжээчдийн хэсэг томилогдон ажиллаж дүгнэлт, зөвлөмж гаргасан ба төслийн холбогдох засвар хийсэн. Уг ажлын хүрээнд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023.10.22-ны өдрийн “Чиглэл өгөх тухай” 01/836 дугаар албан бичиг ирүүлсэн ба “Монгол ган цогцолбор I” төслийн концепци, хүчин чадлыг өөрчлөн 1 сая.тн бэлдэц, 500 мян.тн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” байгуулах төслийг хэрэгжүүлэх чиглэлийг өгсөн тул өмнө хийгдсэн ТЭЗҮ, БОННУ зэрэг ажлуудыг 2024 онд шинэчлэн хийх шаардлагатай болсон.</p> <p>2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар:</p> <p>“Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төслийн хүрээнд Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн төсөл болон Шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн төслийг эхний шатанд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Төслийн судалгааны ажлуудыг хийлгэх бэлтгэл ажил /ажлын даалгавар боловсруулах г.м/-ууд хийгдэж байгаа ба нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн төмрийн хүдрийн түүхий эдийн лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтыг эхлүүлэхээр 20 тн дээж бэлтгэн “Алтернатив металлурги” ХХК-д хүргүүлэн дээж бэлтгэлийн ажил хийгдэж урьдчилсан тайланг хүлээн авсан ба хөвүүлэн баяжуулах туршилтын ажлыг эхлүүлсэн.</p> <p>Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн төслийн ТЭЗҮ хийлгэх ажлын даалгаврыг боловсруулж бэлэн болгосон ба “Эрдэнэс Монгол” ХХК-д ТЭЗҮ-ийн ажлыг хэрхэн зохион байгуулах талаар чиглэл хүссэн албан бичиг явуулж, “Эрдэнэс ҮТП” ХХК-иар хийлгүүлэх чиглэлийг өгсөн.</p> <p>“Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр”-ийн төслийн ТЭЗҮ-ийг боловруулж ЭБМЗ-ийн 2024.06.24-ний өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж, хүлээн авах шийдвэр гарсан.</p>
--	--	--	--	--	--

					<p>Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн төсөл ТЭЗҮ-ийг хийх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>5. Кокс, ширэм, хорголж үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн парк: "Инфинити спэйс" ХХК ("Болдтөмөр Ерөө гол" ХХК) өөрийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт нийт 140 га талбайд "Алтанширээт үйдвэрлэл, технологийн парк" байгуулах төслийг 2019-2026 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Цогцолборын хэмжээнд нийт 420 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалтаар жилд 500 мянган тонн хүчин чадалтай ширэмний үйлдвэр бүхий 5 үйлдвэр байгуулагдах ба эхний 4 үйлдвэр нь ширэмний үйлдвэрээ түүхий эдээр хангах зорилготой.</p> <p>Төслийн явц 2019-2022 онд хийгдсэн ажил:</p> <ul style="list-style-type: none"> • 110/10 кВт-ын 9.4 км цахилгаан дамжуулах агаарын шугам • 6.3 МВт-ын цахилгааны дэд станц • 12 км төмөр зам • Түүхий эд болон бүтээгдэхүүнийг тээвэрлэх төмөр зам, авто замын бүтээн байгуулалтуудыг тус тус гүйцэтгэсэн. • Төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. • Төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэрийг барьж байгуулсан. • Коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжийн үйлдвэр, ширэмний үйлдвэрийн ТЭЗҮ-ийг тус тус боловсруулж "Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөл"-өөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. • Үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах бэлтгэл ажлын хүрээнд технологийн түвшний үнэлгээ, паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан холбогдох зөвлөлөөр хэлэлцүүлж, дэмжигдсэн.
--	--	--	--	--	---

					<ul style="list-style-type: none"> • ҮТП байгуулах газрыг Дорноговь аймгийн ИТХ-ын 2023.03.22-ны өдрийн 11/12 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. • Паркт байгуулах төмрийн хүдэр нойтон аргаар баяжуулах үйлдвэр болон нүүрс баяжуулах үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2023 оны 07 сард Байгаль орчин, аялал жуулчлалын яам хэлэлцэж, баталсан. • Засгийн газрын 2023.07.05-ны өдрийн 267 дугаар тогтоолоор үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 15 жилийн хугацаатай олгосон. • Коксын үйлдвэрийн газар, шороо, суурийн цутгалтын ажлыг хийж дуусгасан. • Коксын үйлдвэрийн хүчин чадал 2.6 мян.тн/жил ба эхний ээлжинд 600 мян.тн/жил хүчин чалалтай үйлдвэр байгуулахаар ажиллаж байна. Коксын зуухны өрлөгийн ажлын явц 40 орчим хувийн гүйцэтгэлтэй байна. • Төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэрийн туршилт, тохируулгын ажлыг хийж, туршилтын журмаар ажиллуулж байна. <p>Түүхий эд ачих, буулгах талбайг бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна.</p>	
6	4.2.14. Уул уурхайн ордыг ашиглалтад оруулж, өндөр технологийн хүнд үйлдвэрийн дараах цогцолборуудыг барьж, байгуулна. Үүнд: Уул уурхайн ордууд: Таван толгойн нүүрсний орд; Оюутолгойн далд уурхай; Дорноговийн цахиурын орд; Цагаан суваргын орд;	2020 2050	-		<p>1. <i>Тавантолгойн нүүрсний орд:</i> “Эрдэнэс-Таван толгой” ХК нь Цанхийн зүүн хэсэгт 2010 оны 8 дугаар сарын 27 нд, Цанхийн баруун хэсэгт 2013 оны 2 дугаар сарын 16 нд уурхайн үйл ажиллагааг эхлүүлсэн бөгөөд олборлолт, экспорт төлөвлөгөөний дагуу явагдаж байна. “Эрдэнэс-Таван толгой” ХК нь Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, Тавантолгой түлш, Тавантолгой дулааны цахилгаан станц, Тавантолгойн нүүрс ачих байгууламж зэрэг үндэсний хэмжээний томоохон төслүүдэд санхүүжилтэд нийтдээ 3,340,753 сая төгрөг зарцуулсан байна. Нүүрс баяжуулах үйлдвэрийн эхний модулыг буюу жилийн 10 сая.тн хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтад оруулсан.</p> <p>2. <i>Оюутолгойн далд уурхай:</i></p>	50

	<p>Хармагтайн орд; Литийн орд; Газрын ховор элементийн хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлнэ. Хүнд үйлдвэр: Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр; Нефть-хими, кокс-хими, металлургийн үйлдвэр; Нүүрс угаах үйлдвэр; Нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл, технологийн парк; Ган төмөрлөгийн үйлдвэр; Жонш баяжуулах үйлдвэр; Алт цэвэршүүлэх үйлдвэрийг тус тус барьж байгуулна.</p>				<p>2024 оны 6 дугаар сарын байдлаар далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 95.4 хувьд хүрсэн. Ажлын багцуудаар ангилбал налуу амны туузан дамжуургын угсралтын ажлын гүйцэтгэл 97 хувь, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл 56.1 хувь, агааржуулалтын 3-р ба 4-р босоо амны малталт нэвтрэлтийн ажил дуусаад байна. 2024 оны 1-5 дугаар сард Далд уурхайн бүтээн байгуулалтад 254 сая ам.доллар, нийт төслийн хугацаанд 6,319 сая ам.доллар зарцуулаад байна. 3. Цагаан суваргын орд: Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 1 дүгээр албан даалгаварт тусгагдсан Цагаан суваргын зэс, молибдений төслийг эрчимжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэн Засгийн газрын 2022.04.20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулсан. Монгол Улсын засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 24 дүгээр тэмдэглэлийн 1-д Цагаан суваргын зэс, молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд тоног төхөөрөмж суурилуулалт, барилгын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай гадаадаас ажиллах хүч, мэргэжилтнийг авах талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авч ажиллахыг УУХҮЯ, ХНХ-ийн сайд нарт даалгасан. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. -Анхан бутлуурын хүчтгэсэн хананы угсралт дууссан, -Барилга болон тоног төхөөрөмжийн суурийн цутгалт хийгдсэн. -Барилгын металл хийц угсралтыг хийсэн. Төслийн бүтээн байгуулалтын ажил 69%-тай. 4. Хармагтайн орд Хармагтайн алт-зэсийн орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос урд зүгт 490 км зайд, Оюу толгой уулын баяжуулах үйлдвэрээс зүүн хойд зүгт 120 км зайд, Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн уурхайгаас зүүн хойд зүгт 73 км зайд, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвөөс зүүн хойш ойролцоогоор 60 км зайд тус тус байрлана. Хармагтайн MV-017387 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 6,647 га талбайг Занаду Майнз Компанийн охин компани болох Оюут-Улаан ХХК эзэмшдэг.</p>
--	---	--	--	--	---

					<p>2010 онд (A+B+C) зэрэглэлээр 86,567,105.0 тн хүдрийн, 38.4 тн алт, 348,000.0 тн зэсийн нөөцийг Улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Нэмэлт хайгуулын ажлын үр дүнд ордын нөөцийг дахин тооцоолж 2018 онд ордын нийт баттай, бодитой, боломжтой (A+B+C) зэрэглэлээр хүдрийн нөөцийг 111,926,218.0 тн, алт 51.9 тн, зэс 512,904.0 тн, мөнгө 129.6 тн гэж шинэчилэн тооцсон.</p> <p>Ордын Ил уурхайгаар ашиглах боломжтой 56,400,821.0 тн хүдэрт 23.1тн алт, 223,727.0 тн зэс, 48.0тн мөнгө, Далд уурхайгаар ашиглах боломжтой 35,592,693.0 тн хүдэрт 22.6 тн алт, 214,836.0 тн зэс, 67.4тн мөнгө гэж тооцсон.</p> <p>5. Литийн ордын төсөл: Хөхдэлийн хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд 2009-2011 онд хайгуул хийж литийн хүдрийн нөөц баттай, бодитой болон боломжтой (A+B+C) нөөцийг 278.76 сая.тн-оор, литийн нөөцийг 435.48 мян.тн-оор тогтоосон.</p> <p>Хөх дэлийн ордын зүүн хойд болон баруун хэсгүүдэд 2012-2020 онд хайгуулын ажил гүйцэтгэж нийт бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр литийн нөөцийг 831,747.0 тн-оор тогтоосон.</p> <p>6. Газрын ховор элемент: Чухал ач холбогдолтой ашигт малтмалын судалгааг хийж, хэтийн төлвийг үнэлэх зорилгоор ӨТТЭ-1-2021 ба ӨТТЭ-2-2022 төслийг хэрэгжүүлж байна. ӨТТЭ-1-2021 төслийг Баруун, Өмнөд болон Төв Монголын хэмжээнд 2021-2023 онд хэрэгжүүлсэн бөгөөд судалгааны ажлын үр дүнгийн тайланг 2024 онд ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн хүлээн авсан. ӨТТЭ-1-2021 төслийн хүрээнд хэтийн төлөвтэй гэж үзсэн Баян-Өлгий, Завхан, Увс, Ховд, Өмнөговь, Дорноговь аймгийн нутагт хамаарах 28 талбайг ялган судалгааг хийсэн.</p> <p>Үүний үр дүнд Хангайн гүний хагарлын дагуу Ургамалын металлогений болон Ханхөхийн металлогений бүсийн зааг хэсэгт газрын ховор элементийн Ихэр илрэлийг шинээр илрүүлж, баялгийн үнэлгээ өгсөн. Мөн Баруун Монголд тархсан Годрой бүрдэл ашигт малтмалын шалгуур болох боломжтойг тодорхойлж, үнэт металл, никель-кобалтын хувьд Сулинхээр, Ховдын бүс болон Монгол Улс-ОХУ-ын Тувагийн хилийн бүс хэтийн төлөвтэй тул цаашид нарийвчилан судлахыг зөвлөсөн байна. ӨТТЭ-2-2022 төслийн хүрээнд Монгол Орны 104 дүгээр уртрагаас зүүн талын хэсэгт газрын ховор элемент, бал чулуу,</p>
--	--	--	--	--	---

					<p>никель, кобальт, берилл, литийн чиглэлээр судалгааг үргэлжүүлэн хийж байна.</p> <p>7. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл: "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын түшиглэн байгуулах "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ"-ийг Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2022.06.22-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж ТЭЗҮ-ийг хүлээн авахаар шийдвэрлэсэн. Үйлдвэрийн ТЭЗҮ-ээр зэсийн үнэ 8340 \$/тн-ны түвшинд 762 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан.</p> <p>- ЗБХБҮ-ээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinxin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна. Үйлдвэрлэлийн туршилтын хамтарсан гэрээний дагуу "ЭҮ" ТӨҮГ нь туршилтад ашиглах 500 тн шигшсэн нүүрс бэлтгэх ажлыг 2023.07.20-ны өдрөөс 2023.08.26-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэж, 2023.09.29-ний өдөр туршилтын үйлдвэрийн талбайд хүргүүлсэн. Туршилтын урьдчилсан үр дүнгээр үйлдвэрийн үндсэн үзүүлэлтүүд тодорхойлогдсон тул батлагдсан ТЭЗҮ-ийг шинэчлэн, тодотгол хийж холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх хүсэлтийг УУХҮЯ-нд ирүүлсэн.</p> <p>- ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-д өгсөн зөвлөмжийн дагуу "Аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж үндэсний болгон боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээ"-ний тендерт "Эс Ай Си Эй" ХХК шалгарч, 2022.11.28-нд гэрээ байгуулан ажиллаж байна. Гүйцэтгэгчээс ирүүлсэн эхний болон дундын тайланг "ЭҮ" ТӨҮГ хүлээж авсан. Олон улсын туршлагыг судалсан судалгааны үр дүнд үндэслэн үндэсний болгон батлуулах стандартуудыг хэлэлцэж, 4-н стандарт сонгосон. Одоогоор стандартуудын эх хувийг авах, орчуулах ажил эхэлсэн бөгөөд зөвлөх багаар хянагдаж байна. Хугацаа их шаарддаг тул гэрээг 2025.07.28-ны өдөр хүртэл</p>
--	--	--	--	--	---

					<p>сунгасан. Ажлын явц 80%, санхүүжилт 60% буюу 207.6 сая төгрөг хийгдсэн.</p> <p>- Судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна. Мөн "Фосфорын ордыг ашиглах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил"-ыг ШУТИС-ын УУХ-ГУУС-тай гэрээ байгуулан ажиллаж, тайланг хүлээн авсан /ажлын санхүүжилт 148.8 сая төгрөг/.</p> <p>- Фосфорын ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах ажил"-ыг төлөвлөсөн боловч фосфорын ордыг ашиглалтын лиценз хувийн компанийн эзэмшилд байдаг шалтгаанаар гүйцэтгэх боломжгүй болсон.</p> <p>- ЗБХБҮ-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг "Хатан далай" ХХК гүйцэтгэсэн. БОАЖЯ-ны мэргэжлийн комиссын 2023.08.30-ны хуралдаанаар тайланг хүлээн авахаар шийдвэрлэсэн. Ажлын явц 100%, санхүүжилт 118.8 сая төгрөг.</p> <p>- ЗБХБҮ-ийн техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх тендерийг зарласан бөгөөд 6 удаагийн тендер амжилтгүй болсон.</p> <p>- Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг эрчимжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан АҮЭБ-ийн сайдын 2024.07.30-ны өдрийн 01/40 албан бичгээр Монгол Улсын Шадар сайд, Үндэсний хороо, ЗГХЭГ болон 16 яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.</p> <p>8. Ган төмөрлөгийн үйлдвэр байгуулах төслүүд:</p> <p>1. "Ган үйлдвэрлэлийн цогцолбор" төсөл:</p> <p>"Эдийн Засаг Хөгжлийн Яам" /хуучнаар/ нь "Кью Эс Си" ХХК-тай 2014 онд байгуулсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг ЗГ-ын 2022.04.13-ны өдрийн 148 дугаар тогтоолоор цуцалсан.</p> <p>2020-2023 онуудад Дарханы төмөрлөгийн үйлдвэр нь гангийн үйлдвэр байгуулах бэлтгэл ажлын хүрээнд ТЭЗҮ, БОННУ, Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн цахилгаан хангамжийн горимын тооцоо, төслийн газар шорооны тэгшилгээний ажил, төмрийн хүдрийн туршилт, "Монгол ган цогцолбор I" төслийн 3D макет хийлгэх зэрэг нилээпгүй ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Толгой компани буюу "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023.10.22-ны өдрийн "Чиглэл өгөх тухай" 01/836</p>
--	--	--	--	--	--

					<p>дугаар албан бичгийг “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-д ирүүлсэн ба “Монгол ган цогцолбор I” төслийн концепци, хүчин чадлыг өөрчлөн 1 сая тн бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” байгуулах төслийг хэрэгжүүлэх чиглэлийг өгсөн тул өмнө хийгдсэн ТЭЗҮ, БОННҮ, бусад судалгааны ажлуудыг 2024 онд шинэчлэн хийх шаардлагатай болсон.</p> <p>2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар:</p> <p>1.“Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төслийн хүрээнд Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн төсөл болон Шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн төслийг эхний шатанд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Төслийн судалгааны ажлуудыг хийлгэх бэлтгэл ажил /ажлын даалгавар боловсруулах г.м/-ууд хийгдэж байгаа ба нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн төмрийн хүдрийн түүхий эдийн лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтыг эхлүүлэхээр 20 тн дээж бэлтгэн “Алтернатив металлурги” ХХК-д хүргүүлэн дээж бэлтгэлийн ажил хийгдэж урьдчилсан тайланг хүлээн авсан ба хөвүүлэн баяжуулах туршилтын ажлыг эхлүүлсэн.</p> <p>Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн төслийн ТЭЗҮ хийлгэх ажлын даалгаврыг боловсруулж бэлэн болгосон ба “Эрдэнэс Монгол” ХХК-д ТЭЗҮ-ийн ажлыг хэрхэн зохион байгуулах талаар чиглэл хүссэн албан бичиг явуулж, “Эрдэнэс ҮТП” ХХК-иар хийлгүүлэх чиглэлийг өгсөн.</p> <p>“Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр”-ийн төслийн ТЭЗҮ-ийг боловруулж ЭБМЗ-ийн 2024.06.24-ний өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж, хүлээн авах шийдвэр гарсан.</p> <p>Мөн БНХАУ-ын “Бугатын ган төмөрлөгийн групп” компаниар төслийн концепцийн судалгааг хийлгэж 2024 оны 06 дугаар сард хүлээн авсан.</p> <p>Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн төсөл ТЭЗҮ-ийг хийх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>2. Кокс, ширэм, хорголж үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн паркийн төслийн хүрээнд “Инфинити спэйс” ХХК (“Болдтөмөр Ерөө гол” ХХК) өөрийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт нийт 140 га талбайд “Алтанширээт</p>
--	--	--	--	--	--

					<p>үйдвэрлэл, технологийн парк” байгуулах төслийг 2019-2026 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Цогцолборын хэмжээнд нийт 420 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалтаар жилд 500 мянган тонн хүчин чадалтай ширэмний үйлдвэр бүхий 5 үйлдвэр байгуулагдах ба эхний 4 үйлдвэр нь ширэмний үйлдвэрээ түүхий эдээр хангах зорилготой.</p> <p>Төслийн явц:</p> <ul style="list-style-type: none"> • 110/10 кВт-ын 9.4 км цахилгаан дамжуулах агаарын шугам • 6.3 МВт-ын цахилгааны дэд станц • 12 км төмөр зам • Түүхий эд болон бүтээгдэхүүнийг тээвэрлэх төмөр зам, авто замын бүтээн байгуулалтуудыг тус тус гүйцэтгэсэн. • Төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. • Төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэрийг барьж байгуулсан. • Коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжийн үйлдвэр, ширэмний үйлдвэрийн ТЭЗҮ-ийг тус тус боловсруулж “Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөл”-өөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. • Үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах бэлтгэл ажлын хүрээнд технологийн түвшний үнэлгээ, паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан холбогдох зөвлөлөөр хэлэлцүүлж, дэмжигдсэн. • ҮТП байгуулах газрыг Дорноговь аймгийн ИТХ-ын 2023.03.22-ны өдрийн 11/12 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. • Парк байгуулах төмрийн хүдэр нойтон аргаар баяжуулах үйлдвэр болон нүүрс баяжуулах үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2023 оны 07 сард Байгаль орчин, аялал жуулчлалын яам хэлэлцэж, баталсан. • Засгийн газрын 2023.07.05-ны өдрийн 267 дугаар тогтоолоор үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 15 жилийн хугацаатай олгосон.
--	--	--	--	--	--

					<ul style="list-style-type: none"> • Коксын үйлдвэрийн газар, шороо, суурийн цутгалтын ажлыг хийж дуусгасан. • Коксын үйлдвэрийн хүчин чадал 2.6 мян.тн/жил ба эхний ээлжинд 600 мян.тн/жил хүчин чалалтай үйлдвэр байгуулахаар ажиллаж байна. Коксын зуухны өрлөгийн ажлын явц 40 орчим хувийн гүйцэтгэлтэй байна. • Төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэрийн туршилт, тохируулгын ажлыг хийж, туршилтын журмаар ажиллуулж байна. • Түүхий эд ачих, буулгах талбайг бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна. <p>3. Metallургийн кокс, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, технологийн парк:</p> <p>“Си Өү Эй Эл” ХХК нь “Гэрэлт говь” үйлдвэрлэл, технологийн паркийг Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутагт “Си Өү Эй Эл” ХХК-ийн MV-016865 дугаар ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайтай хил залган Айлбаян нүүрсний ордын урд 250 га газарт, тус ордын дэд бүтэц болон бусад нөөц бололцоонд тулгуурлан байгуулж, хөгжүүлэхээр төлөвлөж, Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын “Газрын орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай” 2022 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 10/10 дугаар тогтоолоор парк байгуулах 250 га газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан.</p> <p>“Гэрэлт говь” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд жилд 3 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэр, 600 мянган тонн металлургийн кокс үйлдвэрлэх хүчин чадалтай коксын үйлдвэр, коксын үйлдвэрээс гарах хаягдал дулааныг боловсруулж 18 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх цахилгаан станцыг байгуулахаар төлөвлөж паркийн хөгжлийн төлөвлөгөө, үйлдвэрүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, техник, технологийн түвшний үнэлгээ, байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажлуудыг гүйцэтгэсэн бөгөөд Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 267 дугаар тогтоолоор “Гэрэлт говь” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Си Өү Эй Эл” ХХК-д 15 жилийн хугацаатай олгосон.</p> <p>Төслийг 2023-2039 оны хооронд 3 үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд нүүрс баяжуулах үйлдвэр, дэд бүтэц болон төмөр замын бүтээн байгуулалтыг 2023-2024 онд,</p>
--	--	--	--	--	--

					<p>металлургийн коксын үйлдвэр болон хаягдал дулаан ашиглан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх цахилгаан станцыг 2024-2025 онд бүрэн ашиглалтад оруулж, 2025-2039 он хүртэлх хугацаанд үйлдвэрлэл, технологийн паркийн хэвийн үйл ажиллагаа, цаашдын хөгжлийг хангахаар төлөвлөсөн бөгөөд 2024 оны 08 дугаар сарын байдлаар Айлбаян уурхайгаас Зүүн баян-Ханги чиглэлийн 22.5 км төмөр замын бүтээн байгуулалт 97%, 3.0 сая.тн Нүүрс угаах үйлдвэр байгуулах ажлын гүйцэтгэл 90%, металлургийн коксын үйлдвэрийн бүтээн байгуулалт 20%, паркийн талбайн оффис зэрэг бусад дэд бүтцийн ажил 60%, 18МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр байгуулах ажлын гүйцэтгэл 20%</p> <p>Төслийн нийт бүтээн байгуулалтын ажил 50 орчим хувийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>4. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэр байгуулах: “Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэр байгуулах” төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэс алт ресурс” ХХК 2020-2021 онд олон улсын 20 гаруй компанитай холбоо тогтоож төсөл дээр санал авсан ба “түлхүүр гардуулах” нөхцөлөөр 4 компани (Сымбат инженеринг, Шинхай групп, “Кронимет Майнинг, Зижин Майнинг) санал ирүүлсэн. “Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаарх санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий” ажлын хэсгийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021.10.01-ний өдрийн А/100 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн дүгнэлтийг 2021.12.09-ний өдрийн 03/678 дугаар албан бичгээр УУХҮЯ-нд ирүүлсэн.</p> <p>БНКазУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яаманд 2023.02.17-ны өдрийн 02/475 албан бичгээр БНКазУ-ын “Сымбат инженеринг” ХХК-тай цаашид баримтлах байр сууриа УУХҮЯ-ны зүгээс илэрхийлсэн бөгөөд 2024 оны 08 дугаар сарын байдлаар төслийн хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүй хэвээр байна.</p>	
7	4.2.15. Говийн бүс рүү ус дамжуулах хоолой барьж байгуулна.	2020 2050	-		<p>Тус яамнаас Тавантолгойн ордыг түшиглэн баригдах төслүүдийн усан хангамжийн асуудлын талаар танилцуулга бэлтгэж, Засгийн газрын 2022.01.26-ны өдрийн ээлжит</p>	90

					<p>хуралдаанд танилцуулж, хуралдааны 6 дугаар тэмдэглэлийг гаргуулсан.</p> <p>Говийн бүсийн гүний усыг ашиглах төслүүдэд Загийн усны хоолойн болон Цагаан цавын гүний усны төслүүд хамрагдсан. Эхний ээлжинд Загийн усны хоолойн төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд усны нөөц нь 63.65 л/сек, ус дамжуулах хоолойн урт 70 км, нийт хөрөнгө оруулалт нь 118.4 тэрбум төгрөг, 1 м3 усн татах өртөг 3,611.0 төгрөг, шинээр бий болох ажлын байр 61 хүн, төслийн өгөөжийн дотоод норм 4.36%, хөрөнгө оруулалтаа 16 жилд нөхөнө. Төсөл хэрэгжсэнээр 10 сая/тн хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэрийн усны хэрэгцээг бүрэн хангана.</p> <p>Нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах “Загийн усны хоолой”-н газрын доорх усны ордоос ус татах шугам хоолойн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр 1-р хэсэг ажлыг “НАБСАН” ХХК болон “Тэргүүн Инвест” ХХК-ийн түншлэл, 2-р хэсэг ажлыг “Эс энд Эй Трейд” ХХК болон “Бридж Констракшн” ХХК-ийн түншлэл, 3-р хэсэг ажлыг “ЧММ” ХХК болон “Сан” ХХК-ийн түншлэлүүд гүйцэтгэж ажилласан.</p> <p>-Загийн усны хоолойгоос ус татах шугам хоолойн Цахилгаан хангамжийн техникийн комиссыг Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлагдсан бүрэлдэхүүнээр ажиллуулж, холбогдох үүрэг даалгаврын дагуу ажлыг дуусгаж ЦДАШ-ын хэсэгт улсын комисс ажиллуулах хүсэлтийг ЭХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>-Усны гүний худаг, ус цуглуулах шугам, гол шугам хоолой, өргөх насос станцуудыг шалган туршилт хийн ус дамжуулах хоолойнуудыг угааж 1500 м3-ийн усан сангуудыг усаар дүүргэсэн. Туршилт тохируулгыг үргэлжлүүлэн хийж байна.</p> <p>Ус хангамжийн төсөл нь Загийн усны хоолойн хэсэгт нийт 14 ш ашиглалтын цооног гаргаж, усыг салбар шугам хоолойгоор цуглуулан нэгтгэж өргөлтийн насос станцуудын тусламжтайгаар нийтдээ 61,6км урттай хөрсний хөлдөлтийн гүнээс доош ухаж суурилуулсан хос хуванцар хоолойгоор шахаж уурхайн ойролцоо байрлах 1500м3 багтаамжтай хос төмөр бетон дугуй хэлбэрийн усан санд хүргэх юм. Энэхүү усан сангаас Баяжуулах үйлдвэр хэрэглэгчид рүү ус хүргэгдэнэ. Шугам хоолой дээр сэлгэн залгах, ус юүлэх, усны хий гаргах зэрэг үзлэгийн худгууд</p>
--	--	--	--	--	--

					байрлана. Ус хангамжийн системд 950-1000 квт цахилгаан хэрэглэх бөгөөд 35кВ-ын агаарын шугамаар дамжуулна.	
8		4.2.16. Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна.	2020 2050	-	БНЭУ-ын Экспорт-Импорт банкны хөнгөлөлттэй зээлээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн бүтээн байгуулалтын ажлын ерөнхий 4 багцын гүйцэтгэл дараах байдалтай байна. Төслийн нийт гүйцэтгэл 13.0%-тай. Үүнд: ЕРС-1. Технологийн бус барилга байгууламжийн угсралтын ажлын гүйцэтгэл 99.9 хувийн гүйцэтгэлтэй. Нийт 9 барилгаас 3 барилгад улсын комисс ажилласан, ЕРС-2. Үйлдвэрийн Анхдагч технологийн байгууламж багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 2,1%-тай, ЕРС-3. Үйлдвэрийн цахилгаан станцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 3,3%-тай, ЕРС-4. Лицензтэй технологийн байгууламжийн ерөнхий гүйцэтгэгчээр БНЭУ-ын Megha Engineering & Infrastructures Limited компани шалгарч 2023 онд ажлыг эхлүүлсэн. Түүнчлэн газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах дамжуулах хоолойн гүйцэтгэл 2024.7.01-ний байдлаар 41.7%-тай байна. Бүтээн байгуулалтын ажлын хүрээнд нийт 366км шугам хоолойг цувьж байрлуулан, 354км шугам хоолойг гагнаж, 344км шугам хоолойд шалгалт, сорилт хийж, 73км шугам хоолойг булж далдлах ажлыг гүйцэтгэсэн байна.	13
9		4.2.17. Гадаад, дотоод зах зээлд чиглэсэн гүн боловсруулалтын технологид суурилсан хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2020 2050	-	ЗГ-ын 2022.03.16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр даалгасны дагуу “Аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө (үйлдвэр тус бүрээр эдийн засгийн үр өгөөжийг харуулсан)-г дахин нарийвчлан боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар УУХҮСайдын 2022.05.24-ний өдрийн 01/1500 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд “Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор үйлдвэрлэл, технологийн парк”, Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр” болон “Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл”, Оюутолгойн ордыг түшиглэн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”, Дархан-Уул аймагт	30

						“Монгол ган цогцолбор-1” төсөл, “Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр”, “Алтанширээт аж үйлдвэрийн парк” гэх зэрэг Хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан нэмүү өртөг шингэсэн, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, шинээр ажлын байр бий болгох мега төслүүдийг ШСБ-ын хөгжлийн төслүүдийн жагсаалтад оруулж, төслийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан төслийн хэрэгжилт, явцын талаар 7 хоног бүр төсөл хэрэгжүүлэгчээс тайлан авч, ЭЗХЯ-нд хүргүүлэн ажиллаж байна.	
10		4.2.18. Боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэлхийн брэндийн түвшинд хөгжүүлнэ.	2020 2050	-		Хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан нэмүү өртөг шингэсэн, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, шинээр ажлын байр бий болгох ажлын хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлж байна. 1. “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр 2. Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах 3. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах 4. Катодын зэс үйлдвэрлэх төсөл 5. Монгол ган цогцолбор-1 төсөл 6. Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төсөл 7. Алтанширээт аж үйлдвэрийн парк 8. Газрын тос боловсруулах үйлдвэр Эдгээр төслүүд хэрэгжсэнээр боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспорт нэмэгдэж дотоодын бүтээн байгуулалтад шаардлагатай бараа материал, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгцээг хангана.	30
11		4.2.24. Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.	2020 2050	-	Батлагдсан: 40,000.00 Гүйцэтгэл: 22,057.48 Санхүүжилт: 11,073.40	- Геологийн 1:50 000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн Дөч гол-50, Халзан овоо-50, Өндөр ширээт-50, Хайрхан овоо-50, Үнэгт уул-50, Цэцэрлэг-50, Уушгийн улаан-50, Торлог уул-50 төслүүдийн үр дүнгийн тайланг 03 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (ЭБМЗ)-ийн УТХ-2024-04, УТХ-2024-05, УТХ-2024-06 хурлаар хэлэлцэн хүлээн авснаар Монгол Улсын 31 085.73 км2 талбайг бүрсэнээр нутаг дэвсгэрийн 46.9%-ийг хамруулсан.	90

					<p>-Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох “УГЗ-200-Д-VII” төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн УТХ-2024-05 дугаар хуралдаанаар хэлэлцэн хүлээн авснаар Улсын геологийн иж бүрдэл зураг зохиох ажил бүрэн хэрэгжсэн.</p> <p>- Агаарын геофизикийн 1:200000-ны масштабтай Ховд-2020 төслийн судалгааны үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн УТХ-2024-04 хуралдаанаар хэлэлцэн хүлээн авснаар Монгол орны нутаг дэвсгэрийн 66.6%-ийг агаарын геофизикийн судалгаанд хамруулсан. Энэ ажлын үр дүнд Монгол Улсын 104,044 км2 нутгийн геологийн тогтоцыг зайнаас тандан судалж, соронзон орон, нийлбэр цацраг идэвхжил, газрын калийн агуулга, газрын тори-ийн агуулга, газрын ураны агуулгын зургийг зохиосон.</p> <p>- Монгол орны нутагт 2019-2022 онд гүйцэтгэсэн 1:1000000-ын масштабтай геохимийн зураглал, дагалдах мэдээллийн сан бүрдүүлэх төслийн ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авснаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийг 1:1000000-ын масштабтай геохимийн зураглалд бүрэн хамруулсан.</p> <p>- Эрдэнэт хот, Ховд хот, Дархан хотын суурьшлийн бүсийн хэмжээнд гүйцэтгэсэн геозкологи, гидрогеологийн судалгааны үр дүнгийн тайлан болон Монгол орны төв, хойд бүсийн 602,984.0 км2 талбайн хэмжээнд гүйцэтгэсэн Гүний хагарал төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэн хүлээн авсан. Үүний үр дүнд 3 хот суурингийн хэмжээнд геозкологийн өнөөдрийн түвшинг тодорхойлон үнэлгээ өгсөн төдийгүй цаашид экологи-геологийн чиглэлээр авах арга хэмжээний санал бүхий зөвлөмжүүдийг гаргасан. Мөн Монгол орны хойд бүсийн хэмжээнд идэвхитэй гүний хагарлуудыг шинэчилэн тодорхойлж, халуун рашаануудын хэмжээнд геотермийн судалгааг хийж, үнэлсэн.</p> <p>- Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металлын эрэл үнэлгээний “ЭҮ-1-2021”, “ЭҮ-2-2022”, “ЭҮ-3-2022” төсөл, критик ашигт малтмалын чиглэлээр ӨТТЭ-1 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэн хүлээн авсан. Үүний үр дүнд Баруун, Дорнод болон Өмнөд Монголын сонирхол татсан талбайнуудад судалгааг гүйцэтгэн хэтийн төлвийг үнэлсэн.</p> <p>- Монгол Улсын геологийн салбарт олон улсын түвшинд ашиглагдаж буй судалгааны техник, технологийг нэвтрүүлж, геологийн судалгааны үр дүн, түүний өгөөжийг дээшлүүлэх,</p>
--	--	--	--	--	---

					<p>чанаржуулах зорилгоор Монгол орны Өмнөд бүсийн 200 мянган км² талбайг хамарсан Агаарын геофизикийн цогцолбор судалгааны "Агаарын геофизик-2024" төслийн шинээр хэрэгжүүлж эхлээд байна.</p> <p>- Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-ын хамтарсан "Хойт,Төв, Зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени" төслийн 5-р үе шатны "Төв Ази 3D 5-р шат" ажлын 2021-2023 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. Үүний үр дүнд Говийн Алтайн хэмжээнд геологийн региональ судалгааны ажлын түвшинг дээшлүүлж, шинжлэх ухааны ая холбогдол бүхий олон тооны баримтуудыг шинээр бүрдүүлсэн.</p> <p>- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох ажлын хүрээнд 2024 оны эхний хагас жилд 144,187 гектар талбайг хамарсан 50 талбайд сонгон шалгаруулалт зарлаж, түүнээс 26 талбайд тусгай зөвшөөрөл олгосон. Үүний үр дүнд улсын төсөвт 21.1 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.</p> <p>-Улс орны хэмжээний ач холбогдол бүхий авто замын бүтээн байгуулалтын ажилд нэн шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын асуудлыг шийдвэрлэх зорилгоор тухайн асуудлыг судлан, замын далан болон бусад зориулалтаар ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалыг олборлох талбайн хил заагийг тодорхойлон Засгийн газрын 2024 оны 139, 228, 236 тогтоолоор батлуулсан.</p> <p>- Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд 2024 оны эхний хагас жилд 10 төрлийн ашигт малтмалын 20 ордын нөөц бүртгэгдсэн байна. Үүнээс 2024 оны 08 сарын 27-ны өдрийн байдлаар алт /шороо/ 422.90 кг, төмөр 211.83 мян.тн хүдрээр, хайлуур жонш 1,664.45 мян.тн, нүүрс 7,710.97 сая.тн, шохойн чулуу 27,924.99 мян.тн, дайрга 10.43 сая м³, өнгөлгөөний чулуу 15,471.79 мян м³, элс 1,129.32 мян.м³, элс-хайрга 1,485.52 мян.м³, базальт 12,251.49 мян.тн-ыг улсын нэгдсэн санд бүртгэн нөөцийг өсгөсөн.</p>	
12	4.4. Бүс нутгийн эдийн засаг,	4.4.12. Дотоодын боловсруулах аж үйлдвэрийн	2020 - 2050		Дотоодын боловсруулах аж үйлдвэрийн бүтээн байгуулалтыг дэмжин хөгжүүлэх, бүтээгдэхүүнийг өөрийн өртгийг бууруулах, төрөлжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр	50

	<p>худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө.</p>	<p>бүтээгдэхүүнийг гадаад өрсөлдөөнөөс хамгаалах бодлого зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.</p>			<p>Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон хамт өргөн мэдүүлсэн Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг УИХ-аас 2022.07.05-ны өдөр баталж, 2022.08.01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн бөгөөд эдгээр хууль батлагдсанаар Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар 1 удаа сунгаж, гаалийн албан татвараас чөлөөлөх, үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрыг эхний 10 жилд газрын төлбөрөөс чөлөөлөх, паркийн нутаг дэвсгэр дэх үл хөдлөх эд хөрөнгийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас эхний 5 жилд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлөх, паркийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор үнэт цаас гаргах, гадаадын хөнгөлөлттэй зээлд хөрөнгийн баталгаа гаргах, паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын бонд болон холбогдох бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх, паркийн нутаг дэвсгэрт гаалийн тусгай бүс, гаалийн баталгаат үйлдвэр байгуулах, гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсөн горимоор олгох, паркийн удирдлага, нэгж үйлдвэрлэлийн ажилчдыг сургах, дадлагажуулах зорилгоор гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ үзүүлсэн бол ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу тогтворжуулах гэрчилгээ олгох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах зэрэг дэмжлэгийг паркийн удирдлага нэгжийн үйл ажиллагаанд үзүүлэх эрх зүйн орчин бүрдээд байна.</p> <p>Мөн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасан Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн болон</p>	
--	---	--	--	--	--	--

					<p>нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгаж, гаалийн албан татвараас чөлөөлөх харилцааг нарийвчлан зохицуулсан "Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-ыг Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 337 дугаар тогтоолоор баталсан. Тус журмын хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт баригдаж байгаа "Алтанширээт" үйлдвэрлэл, технологийн паркийн төслийн барилга угсралтад зориулан "Инфинитиспейс" ХХК-ийн импортоор оруулж ирэх тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар сунгах шийдвэрийг Засгийн газрын 2024 оны 191 дугаар тогтоолоор гаргасан. 2. Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутаг дэвсгэрт баригдаж байгаа "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн паркийн төслийн барилга угсралтад зориулан "Си Өү Эй Эл" ХХК-ийн импортоор оруулж ирэх тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг сунгуулах хүсэлтийг холбогдох баримт материалын хамт Сангийн сайдад 2024.08.21-ний өдөр албан бичгээр хүргүүлсэн. 	
13	4.6. Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно.	4.6.1. Үндэсний баялгийн сангийн эрх зүйн орчныг төгөлдөржүүлж, зохион байгуулалтын шинэчлэлт хийнэ.	2020 - 2050		<p>Монгол Улсын Үндсэн хуулийн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгаа зэргийг боловсруулж, хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн</p>	100

					<p>хуралдаанаар танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022.06.17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022.09.21-ний өдрийн 54 дүгээр тушаалаар Үндэсний баялгийн сангийн хууль, эрх зүйн орчныг нарийвчлан судалж, боловсруулалтын шатанд байгаа орчуулийн төслийг төрийн өмчит компанийн бүтэц зохион байгуулалттай уялдуулан боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, тус ажлын хэсгийн дүгнэлтээр УИХ-д өргөн мэдүүлэхээр хүргүүлсэн хуулийн төслийг дахин нарийвчлан боловсруулсан.</p> <p>Уг хуулийн төсөл УИХ-аар хэлэлцэгдэж, 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр батлагдсан.</p>	
14		4.6.11. Монгол Улсын иргэдэд давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг хүртээнэ.	2020 - 2050		<p>"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөл 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 09 дүгээр тогтоолыг баталж, компанийн 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 90 /ерэн/ төгрөгийн ногдол ашгийг 1072 хувьцаа эзэмшигч 2.5 сая иргэдэд олгох ажлыг 2020 онд зохион байгуулсан.</p> <p>Улсын Их Хурлын чуулганы 2020 оны 01 сарын 10 өдрийн хуралдаанаар Иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг баталсан.</p> <p>Иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль батлагдсанаар Төрийн өмчит "Эрдэнэс Монгол" ХХК өөрийн охин компанийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан үнэт цаас гаргах замаар иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн тодорхой хэсгийг төлөх боломж бүрдэхийн зэрэгцээ зээл аваагүй 194 мянган иргэнд Салхитын мөнгөний ордын орлогоос нэг сая төгрөгийн үнэт цаас олгох боломж бүрдсэн.</p> <p>"Эрдэнэс Тавантолгой" ХК 2022 онд 1.3 их наяд төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд нэгж хувьцаанд 108.7 төгрөгөөр тооцож ногдол ашгийг иргэдийн дансанд шилжүүлсэн. Монгол Улсын 3.4 сая иргэнд нийт 351 тэрбум орчим төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр олгосон юм.</p>	100

						Харин 2023 оны тухайд 3.2 их наяд орчим төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 256 мянган төгрөгийг ноогдол ашгийг өнгөрсөн 2024 оны 04 дүгээр сард олгосон.	
	ДҮН						58.0

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
БАРИМТ БИЧГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2024 оны 08 дугаар сарын 28

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээллийн эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хэрэгжилт	Үнэлгээ
				2025	2030	2050						
ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ												
35	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	24.3	30.6	31.4	25.3	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ	Үндэсний статистикийн хороо, Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Уул уурхай, олборлох салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 30% /2024 оны эхний хагас жилийн байдлаар/, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 72% /2024 оны эхний 7 сарын байдлаар/, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 79% /2024 оны 1 улирлын байдлаар/, нийт экспортын орлогын 94% /2024 оны эхний 7 сарын байдлаар/, Төсвийн орлогын 35% /2024 оны эхний хагас жилийн байдлаар/-ийг тус тус бүрдүүлж байна. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар 15.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.2 (16.4%) их наяд төгрөгөөр өссөн байна. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 11.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (21.1%) их наяд төгрөгөөр өсөхөд чулуун, хүрэн нүүрс олборлолт 1.9 (52.9%) тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт 94.6 (1.9%) тэрбум төгрөгөөр өссөн нь тус тус нөлөөлсөн байна.	100

											Харин газрын түүхий тос, байгалийн хий олборлолт 57.6 (9.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар 70.4%-ийг эзэлж байна.	
36	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	10.9	12	14.6	27.4	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ	Үндэсний статистикийн хороо	Салбарын тайлан	Жилд нэг удаа	МУ-ын Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2024 оны эхний хагас жилд 37.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.4 (20.8%) их наяд төгрөгөөр өссөн бөгөөд үүнээс боловсруулах үйлдвэрийн салбар урьдчилсан гүйцэтгэлээр 29.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.3 (16.9%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд: Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 4.3 (22.1%) их наяд төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолтын салбарын борлуулалт 3.5 (32.2%) их наяд төгрөгөөр, металлын хүдэр олборлолт 810.8 (10.6%) тэрбум төгрөгөөр, бусад ашигт малтмал олборлолт 49.5 (21.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2024 оны эхний хагас жилд 1.5 их наяд төгрөг буюу 7.9%-ийг эзэлж байна.	90
40	Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад	хувь	8	70	100	100	Импорт, хэрэглээний хэмжээ, нийт шатахуунд эзлэх хувь,	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны	Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан	Жилд нэг удаа	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт хэрэгжиж буй дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэр 2025-2026 онд ашиглалтад орж бүрэн	19

	нийцүүлэн дотоодоос хангах хувь						2015 он суурь түвшин	төв байгууллага	журам болон тус журмын хавсралт		хүчин чадлаар ажилласнаар өндөр чанарын 339.0 мян.тн автобензин 864.0 мян.тн дизель түлш үйлдвэрлэх бөгөөд шатахууны өсөн нэмэгдэж буй хэрэглээний 50 %-ийг хангана гэсэн тооцоололтой байна. 2023 оны байдлаар нийт 2,415,221 тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 2,132,364 тонн байна. Үүнээс К5 /Евро-5/ ангилалын шатахуун 232,242 тонн буюу нийт шатахууны 11 хувийг эзэлж байсан бол 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1,223,208 тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 1,138,583 тонн байна. Үүнээс К5 /Евро-5/ ангиллын шатахуун 175,219 тонн буюу нийт шатахууны 16 хувийг эзэлж байна.	
	ДҮН										69.6	

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР